

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ” НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**БАЙГАЛЬ ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ
ТӨСВИЙГ ХУУЛЬД ЗААСАН ХЭМЖЭЭГЭЭР ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ҮР ДҮНГ
ТООЦОХ БОДИТОЙ АЖИЛ ХИЙГЭЭГҮЙ БАЙНА.**

АУДИТЫН КОД: : ХӨА-2023/01/ШТА-НА

**Хөвсгөл аймаг
2023 он**

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn
Аудитор: Л.Мандахнаран
Утас: 92118277 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: Ichinkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. https://audit.mn/?page_id=579

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй

А.БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДЭЭГҮЙ, ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДААГҮЙ БАЙНА.

А1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй, менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

А2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг нарийвчлан тусгаж дүгнээгүй байна.

Б. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ХЭМЖЭЭНЭЭС 2021-2023 ОНД НИЙТ 3,198.9 САЯ ТӨГРӨГӨӨР ДУТУУ ТООЦОЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

Б1. Хөвсгөл аймгийн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт хуш модны самрын ургацаас хамаарч жил бүр харилцан адилгүй байна

Б2. БОХНСАХ-ний зардлаас төсвийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсантай холбоотой нийт 256.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

В.БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙГЭЭГҮЙ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

В.1. Байгаль орчны салбарын байгууллагуудын хууль эрх зүйн орчин, үйл ажиллагааны тогтолцоо нь уялдаа холбоогүй байна.

В.2. Хөвсгөл аймгийн БОАЖГ-аас дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, санхүүгийн хяналт, аудитын алба болон төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчил давтагдаж байна.

Дүгнэлт:

Зөвлөмж:

Холбогдох байгууллагын санал:

Товчилсон үгсийн жагсаалт

Товчлол	Товчилсон үгийн тайлал
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНАТ	Байгалийн Нөөц Ашигласны Төлбөр
БОАЖГ	Байгаль Орчин Аялал, Жуулчлалын Газар
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал, Жуулчлалын Яам
БОХНСАХЗ	Байгаль Орчныг Хамгаалах, Нөхөн Сэргээх Ага Хэмжээний зардал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НА	Нийцлийн Аудит
СЯ	Сангийн Яам
СТСХ	Санхүү Төрийн Сангийн Хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ШТА	Шууд Тайлагнах Аудит



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/24

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/04 дүгээр тушаал, 2018 оны А/207 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх тухай” тушаал, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн актыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар, аймаг сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Татварын хэлтэс, Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргаа, Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргаанд тус тус хүргүүлсүгэй.

4. “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга /Г.Мөнгөнхуяг/, аймгийн Засаг дарга /П.Лхагважав/, БОАЖГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Мөнхжаргал, Татварын хэлтсийн дарга Ч.Хуншагай, Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргааны дарга Б.Энхгэрэл, Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргааны дарга Д.Эрдэнэболд нарт зөвлөсүгэй.


5. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Б.Давааням/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР





“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн
аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Төлбөрийн акт, албан шаардлагын дугаар	Зөрчлийн утга
1	53/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Төлбөр барагдуулах тухай
2	54/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Төлбөр барагдуулах тухай
3	55/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Төлбөр барагдуулах тухай
4	56/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Төлбөр барагдуулах тухай
5	57/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Төлбөр барагдуулах тухай
6	77/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Зөрчил арилгах тухай
7	78/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Зөрчил арилгах тухай
8	79/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Зөрчил арилгах тухай
9	80/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Зөрчил арилгах тухай
10	81/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Зөрчил арилгах тухай
11	82/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Зөрчил арилгах тухай
12	83/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Зөрчил арилгах тухай
13	84/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Зөрчил арилгах тухай
14	85/A2260439/ХӨА-2023/01/ШТА-НА	Зөрчил арилгах тухай

--oo0oo--

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бүрэлдэхүүн

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэнэ.

Аудитын зорилт

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах 3 дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт хууль журмын дагуу хэрэгжсэн эсэх.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээг зохион байгуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ

Аудитад аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргаа, Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргаа, Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж буй сум дундын ойн ангиуд, Галт, Жаргалант, Тариалан, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2021-2023 оны үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

Аудитыг нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх бөгөөд төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүй нь аудитын бүх үе шатны туршид үргэлжлэх үйл ажиллагааг хамрах тул аудитын явцад томоохон өөрчлөлт гарсан, гүйцэтгэл, тайлагналын үе шатанд нэмэлт горим хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж болно.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан.

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль

- Ойн тухай хууль
- Усны тухай хууль
- Амьтны тухай хууль
- Газрын тухай хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”
- Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021 оноос 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол)
- Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 11 сарын 18-ний 79 дүгээр тогтоол
- Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 11 сарын 18-ний 80 дугаар тогтоол
- Холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актууд

Аудит хийсэн бүрэлдэхүүн

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Давааням, аудитор Л.Мандахнаран, Г.Ичинхорлоо нар гүйцэтгэсэн.

Үндсэн мэдээлэл

Хөвсгөл аймаг нь нийт 100.6 км квадрат газар нутагтай бөгөөд нутаг дэвсгэрийн 39.8 хувийг ойн сангийн газар эзэлж байна. Ойн сангийн талбай нь 2021 оны байдлаар 4,012.6 га байна. Ойн сангийн 2,929.2 га буюу 73.0% нь хамгаалалтын бүсийн, 1,083.4 га буюу 27.0% нь ашиглалтын бүсийн ойд хамаарч байна.

Хөвсгөл аймгийн нийт усны нөөцийг 9,080 сая м.куб гэж тооцсон бөгөөд үүнээс газрын доорх усны нөөц 2,490.0 сая м.куб, гадаргын усны нөөц 6,590.0 сая м.куб байна.

Хөвсгөл аймгийн ургамлын аймагт 2021 оны байдлаар 68 овогт багтах 340 төрлийн 1147 зүйл ургамал бүртгэгдсэн байна.

Хөвсгөл аймагт 68 зүйл хөхтөн амьтан, 286 зүйл шувуу, 4 зүйл мөлхөгч, 4 зүйл хоёр нутагтан, 4 зүйл загас бүртгэгдсэн байна. Сүүлийн 10 жилд улсын хэмжээнд амьтны нэгдсэн тооллого, үнэлгээ хийгээгүй. Зөвхөн зарим зүйл амьтны тоо толгой, тархац, ашиглалтын нөөцийн судалгаа хийжээ.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн дагуу төвлөрүүлсэн орлого, зарцуулалтын гүйцэтгэл (2021, 2022 оны байдлаар)¹

Хүснэгт №-1

/сая төгрөг/

Үзүүлэлт	2021	2022
Төвлөрүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын дүн	3,317.6	5,495.3
Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтэд зарцуулсан дүн	945.9	1,306.7
Дүн	4,263.4	6,802.0

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс

¹ Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2021, 2022 оны танилцуулга.

Байгаль орчин аялал жуулчлалын сайд Хөвсгөл аймагт байгалийн нөөц ашиглах дээд хязгаарыг 2022 онд доорх үзүүлэлтээр баталсан байна. Үүнд:

- Ойгоос 489.9 мянган м3, Улсын тусгай хамгаалалттай газар нутгаас 35.7 мянган м3 мод бэлтгэхээр,
- Ахуйн зориулалтаар зэрлэг гахай 80, бор гөрөөс 30, Загас 3,500 ширхгийг бариулахаар,
- Үйлдвэрийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын дээд хэмжээг ховор ургамалд 200 кг, элбэг ургамалд 114,550 кг түүхээр тус тус зөвшөөрөл олгосон байна.

Хөвсгөл аймагт Байгаль орчны асуудлыг БОАЖГ нэгдсэн бодлого зохицуулалтаар хангаж, 2 усны сав газрын захиргаа, 4 улсын тусгай хамгаалалттай газар, 4 сум дундын ойн анги тус тусын чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж байна.

А.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдаагүй байна.

А1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй, менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь Төсвийн тухай хууль, Татварын, Ойн тухай, Усны, ан амьтан, ургамал зэрэг хууль тогтоомжийн холбогдох заалтуудтай холбогдон хэрэгжиж байна.

Аудитаар дээрх хуулийн нийцлийг хянаж үзэхэд хоорондоо уялдаа холбоогүй дараах зүйл заалтууд байна. **Үүнд:**

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно” гэж заасан байхад Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.1. “доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас бага болон тэнцүү тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн 60 хувийг 2017 оны төсвийн жилд, 40 хувийг 2018 оны төсвийн жилд, 60 хувийг 2019 оны төсвийн жилд, 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ” гэж заасан нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалттай нийцэхгүй байна.
2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. “Дор дурдсан зориулалтаар ашигласан ус, рашаан тэдгээрийн орчинд төлбөр ногдуулна”, 6.1.1. “хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус” гэсэн байхад Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт дахь “Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны шоо метр тутамд” ногдуулах төлбөрийн хувь хэмжээг тогтоогоогүй нь Төсвийн тухай хуулийн 23.8.9 дахь заалтыг хэрэгжүүлэх боломжгүй байна.

Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөрт хүрээлэн буй орчны тогтвортой байдал, аялал жуулчлалын хөгжлийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд байгаль орчныг хамгаалах талаар дараах зорилтуудыг тусгасан байна. Үүнд

- Ан амьтныг хамгаалах удирдлага, зохион байгуулалтын бодлого, төлөвлөлтийг сайжруулах
- Аймгийн ан агнуур болон сав газрын загас агнуурын менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх

- Байгалын ургамлын ашиглалт, хамгаалалтын менежментийг сайжруулах
- Хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ авах
- Ойн нөөцийн зүй зохистой тогтвортой ашиглалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулна.
- Агаар бохирдуулагч эх үүсвэрийн мэдээлэлд үндэслэн дэвшилтэд технологи нэвтрүүлэх замаар агаарын бохирдлын бууруулж, төв суурин газрын тоосжилтыг арилгана.
- Хог хаягдлыг баялаг болгох замаар байгальд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулна.
- Усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалж, зүй зохистой ашиглан, нөөц, чанарыг, тогтоох хайгуул судалгааны ажлыг хэрэгжүүлнэ.
- Тусгай зөвшөөрлийн асуудлын хуулийн дагуу шийдвэрлэж, ашигт малтмалын зохистой ашиглалтыг төлөвшүүлнэ.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэн хамгаалалт, удирдлагын чадавхыг сайжруулна.

Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан батлуулж, уг хөтөлбөрт 6 бодлогын хүрээнд 467 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн баталсан байна. Үүнээс Байгал орчныг хамгаалах талаар ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 2021 онд 13 арга хэмжээ, 2022 онд 52 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн үнэлсэн үнэлгээгээр 2021 онд 91.5 хувь, 2022 онд 85.0 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Аймаг сумдын 2021-2024 онд хэрэгжүүлэх Ойн менежментийн төлөвлөгөөг Денс порист ХХК 2020 онд боловсруулсан бөгөөд аймгийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө батлагдах шатандаа явж байгаа хэдий ч уг төлөвлөгөөг баримтлан ажиллаж байна. Сумдын Ойн менежментийн 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын захирамжаар баталсан байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд байгаль орчин, ан амьтныг хамгаалах Менежментийн төлөвлөгөөг чиглэл тус бүрээр нь гарган хэрэгжүүлсэн хэдий ч хэрэгжих хугацаа дууссан зарим менежментийн төлөвлөгөөнүүдийг шинэчлэн боловсруулаагүй байна.

Менежментийн төлөвлөгөө.

Хүснэгт №-2

Чиглэл	Газрын нэр	Батлагдсан шийдвэр	Хэрэгжих хугацаа		
Ус	Шишхэд голын сав газар	БОАЖС-ын 2018 оны А/92 дугаар тушаал	1-р үе шат 2018-2021 он	2-р үе шат 2022-2025 он	3-р үе шат 2026-2030 он
	Дэлгэрмөрөн голын сав газар	БОАЖС-ын 2016 оны А/121 дугаар тушаал	2015-2017 он	2018-2021 он	
	Хөвсгөл нуур, Эгийн голын сав газар	Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/228 дугаар тушаал	2014-2021 он		
Ой	Аймгийн ойн менежментийн төлөвлөгөө	Батлагдах шатандаа	2021-2024 он		
	Сумд	Хөвсгөл аймгийн Засаг даргын 2015 оны А/433 дугаар захирамж	2021-2024 он		
Ан агнуур болон Загас барих	Дэлгэрмөрөн, Шишхэд, Хөвсгөр нуур-Эгийн голын сав газар	2015 он /Аргаль агнуур судлалын төв/	2016 оноос		
	Аймгийн ан агнуур	2021 он /Агнуур судлалын нийгэмлэг ТББ/	2021-2025		

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын усны менежментийн төлөвлөгөө 2016-2021 онд хэрэгжиж дууссан, Дэлгэрмөрөн голын сав газрын усны менежментийн төлөвлөгөө 2015-2021 онд хэрэгжиж тус тус хугацаа дууссан ч дахин боловсруулаагүй байна.

Хөвсгөл аймгийн Ойн менежментийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх хамгаалах үйл ажиллагааны чиглэлээр:

Хүснэгт №-3

Үйл ажиллагаа	хэмжих нэгж	2021 он			2022 он		
		Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү
Ойн хөнөөлт шавжийн тархалт, голомтын талбайг хянаж, тэмцлийг оновчтой явуулах зорилгоор судалгааны талбайг нэмэгдүүлэх	Мян.га	350	0	-350	400	0	- 400
	Сая. Төг	17.5	17.5	0.0	25.0	24.6	-0.4
Ойн хөнөөлт шавжтай тэмцэх химийн аргын хэрэглээг бууруулж, биологийн аргыг түлхүү хэрэглэж ойн хөнөөлт шавжийн тархалт, голомттой талбайд тэмцэх	Мян.га	45	45	0.0	50	3.6	-46.4
	Сая. Төг	495.0	25.0	-470.0	550.0	81.0	-469.0

Ойн хөнөөлт шавжийн тархалт, голомтын талбайг хянаж, тэмцлийг оновчтой явуулах зорилгоор судалгааны талбайг нэмэгдүүлэх ажлыг хийгээгүй байна.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх химийн аргын хэрэглээг бууруулж, биологийн аргыг түлхүү хэрэглэж ойн хөнөөлт шавжийн тархалт, голомттой талбайд тэмцэх ажлыг 2022 онд 50 га-д хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 3.6 га талбайд буюу 0.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар баталсан Мод тарих үндэсний өдрийн хүрээнд Хөвсгөл аймгийн хэмжээнд 2021 онд 61,453, 2022 онд 272,116 мод бут тарих төлөвлөгөөг боловсруулж ажилласан байна. Үүний гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Бүх нийтээр мод тарих өдрийн мод бут ургуулах ажлын төлөвлөгөө гүйцэтгэл:

Хүснэгт №-4

Хэмжих нэгж	2021 он			2022 он		
	төлөв	Гүйц	Зөрүү	төлөв	Гүйц	Зөрүү
Мод бут ширхэг	61,543	42,063	-19,480	272,116	650,530	378,414
Талбай га	17.6	15.2	-2.4	77.8	155.6	77.8

Бүх нийтээр мод тарих өдрийн ажлын хүрээнд 2021 онд төлөвлөгөөнөөс 19,480 ширхэг, 2.4 га талбайд мод бутыг дутуу

тарьсан, 2022 онд 378,414 ширхэг, 77.8 га-д талбайд мод бутыг тарьж төлөвлөгөөнөөс давуулан биелүүлсэн байна.

Хамгааллын Ойн зурвас байгуулах ажлын төлөвлөгөө гүйцэтгэл:

Хүснэгт №-5

Хэмжих нэгж	2021 он			2022 он		
	төлөв	Гүйц	Зөрүү	төлөв	Гүйц	Зөрүү
Талбай га	8.3	2.1	-6.2	12.5	12.6	0.1
Зардал сая.төг	16.5	10.4	-6.1	25.0	26.7	1.7

Хамгааллын Ойн зурвас байгуулах ажлын хүрээнд 2021 онд 8.3 га талбайд ойн зурвас байгуулахаар төлөвлөж 2.1 га талбайд ойн зурвас

байгуулж 6.2 га талбайн ажил хийгдээгүй.

Ногоон байгууламж байгуулах ажлын төлөвлөгөө гүйцэтгэл:

Хүснэгт №-6

Хэмжих нэгж	2021 он			2022 он		
	төлөв	Гүйц	Зөрүү	төлөв	Гүйц	Зөрүү
Талбай га	2		-2	2.5	2.5	0
Зардал сая.төг	4.0		-4	5.0	0.5	-4.9

Ногоон байгууламж байгуулах ажлын хүрээнд 2021 онд төлөвлөсөн 2 га талбайд ногоон зурвас байгуулах ажлыг гүйцэтгээгүй байна.

Ойжуулалт нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө гүйцэтгэл:

Хүснэгт №-7

Хэмжих нэгж	2021 он			2022 он		
	төлөв	Гүйц	Зөрүү	төлөв	Гүйц	Зөрүү
Талбай га	1,374	233.6	(1,140)	1,443	161	(1,282)
Зардал сая.төг	1,648.0	162.352	(1,485.6)	1,731.6	193.2	(1,538)

Ойжуулалт нөхөн сэргээх ажлыг 2021 онд 1,374 га талбайд хийхээр төлөвлөж гүйцэтгэлээр 233.6 га буюу 17 хувь, 2022 онд

1,443 га талбайд төлөвлөж гүйцэтгэлээр 161 га буюу 11.1 хувьтай ойн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь зарим хууль тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй, орон нутагт хэрэгжүүлэх боломж бүрдээгүй, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээхтэй холбоотой менежментийг төлөвлөгөөг аймгийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлсэн боловч зарим менежментийн төлөвлөгөөний хэрэгжих хугацаа дууссан, төлөвлөсөн зарим үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Ойн тухай хуулийн 17.3.”Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, 17.3.7.”нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах”, 17.3.9.ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих” гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн байна.

A2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг нарийвчлан тусгаж, дүгнээгүй байна.

БОАЖ-ийн сайд нь байгаль орчны чиглэлээр аймгийн Засаг дарга, аймгийн БОАЖГ, Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргаа, Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргаа, Дэлгэрмөрөн сум дундын ойн ангийн дарга нартай гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж ажилласан байна.

Хүснэгт №-8

№	Байгууллагын нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
		2021 он		2022 он	
1	Аймгийн Засаг дарга	83	95.3	82	90.2
2	Байгаль орчин аялал жуулчлалын газар	69	94.3	55	93.1
3	Дэлгэрмөрөн сум дундын ойн анги	59	91.3	60	94.7
4	Дэлгэр мөрөн Шишхэд голын сав газрын захиргаа	39	88.5	39	84.5
5	Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргаа	36	93	48	89.7

БОАЖС нь харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тухайн байгууллагын үндсэн чиг үүрэг, хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг тусгаж үнэлсэн хэдий ч байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаагүй байна.

Аймгийн Засаг дарга нь сумдын Засаг дарга нартай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, дунджаар 2021 онд 77.3 хувь, 2022 онд 75.8 хувьтай үнэлэгдсэн байна. Сумдын Засаг дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг нарийн тусгаж, дүгнээгүй байна.

Б. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хэмжээнээс 2021-2023 онд нийт 3,198.9 сая төгрөгөөр дутуу тооцож төлөвлөсөн байна.

Б1. Хөвсгөл аймгийн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт хуш модны самрын ургацаас хамаарч жил бүр харилцан адилгүй байна.

Хөвсгөл аймгийн байгалийн нөөц ашиглах хэмжээг БОАЖЯ-ны сайдын тушаалаар батлагдсан дээд хэмжээний хязгаарт үндэслэж, аймгийн ИТХ-аас жил бүр ашиглах байгалийн нөөцийн хэмжээг төрөл бүрээр нь тогтоосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-9

№	Байгалийн нөөцийн төрөл	БОАЖЯ-ы сайдын тушаал			Аймгийн ИТХ-ын тогтоол		
		2021	2022	2023	2021	2022	2023
1	Ан амьтан	2020.12.30 №А/701	2022.04.08 №А/89	2023.01.11 №А/05	2021.04.16 №27	2022.06.22 №07	2023.05.02 №12
2	Байгалийн ургамал	2021.06.10 №А/136	2022.06.08 №А/190	Тушаал гараагүй байгаа.	Аймгийн ИТХ-аар сум бүрийн ашиглах дээд хэмжээг тогтоогоогүй байна.		
3	Ойн нөөц	2020.09.28 А/599	2021.08.10 №А/217	2023.08.29 А/327	2020.12.03 №06	2021.02.03 №06	2022.12.02 №05

Аймгийн ИТХ-аас ахуйн зориулалтаар ан амьтан агнах, загас барих хуваарийг сум бүрээр тогтоохдоо 2022 онд Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тогтоосон хязгаараас зэрлэг гахайг 6 ширхгээр, бор гөрөөсийг 7 ширхгээр, загасыг 300 ширхгээр тус тус хэтрүүлэн баталсан байна. Энэ нь Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2. “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 26.1-д заасан дээд хязгаарт багтаан өөрийн нутаг дэвсгэрт агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сум, дүүрэг тус бүрээр тогтооно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Хөвсгөл аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын тайлан болон Мөрөн сумаас бусад сумын нутаг дэвсгэрт тархсан ойн дагалт баялаг, түгээмэл ашиглагддаг ургамлын тархац, нөөцийн судалгааны тайланд Хөвсгөл аймгийн байгалийн ургамал болон ахуйн зориулалтаар агнах амьтны нөөцийг тодорхойлсон байдлыг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт №-10

Байгалийн нөөцийн төрөл	Сумын нэр	Агнуурын тогтоосон нөөц	Аймгийн ИТХ-аас тогтоосон	Зөрүү
Зэрлэг гахай	Тариалан	2	8	-6
Зэрлэг гахай	Ханх	0	3	-3
Зэрлэг гахай	Цагаан-Уул	0	3	-3
Зэрлэг гахай	Цагаан-Үүр	15	25	-10
Зэрлэг гахай	Эрдэнэбулган	15	18	-3
Дүн		24	57	-33
Бор гөрөөс	Ханх	0	3	-3
Бор гөрөөс	Цагаан-Уул	0	5	-5
Дүн		0	8	-8
Алтайн сонгино	Арбулаг	0	300	-300
Хонгорзуллаг	Түнэл	0	1,000	-1000
Дүн		0	1300	-1300

Аймгийн ИТХ-аас 2022 онд байгалийн нөөц ашиглах дээд хэмжээг тогтоохдоо тус тайланд тодорхойлсон байгалийн нөөцийн хэмжээнээс зарим сумдад хэтрүүлэн баталсан байна. **Тухайлбал:** Арбулаг суманд алтайн сонгино, Түнэл суманд Хонгорзуллаг нөөц байхгүй гэж

тогтоогдсон ч тус сумдаас ирүүлсэн саналын дагуу ашиглах дээд хэмжээг хуваарилж өгсөн ба орлогын төлөвлөгөө биелсэн байна. Энэ байдал нь байгалийн нөөц тогтоосон дээрх судалгаа тайлангуудыг бодит гэж үзэх боломжгүйг харуулж байна.

Б1.2. БОАЖГ-аас хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс 2023 оны ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодит байдлаас 207.7 сая төгрөгөөр илүү тооцож төлөвлөсөн байна.

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хоёр дахь хэсэгт заасны дагуу аймгийн БОАЖГ сумдаас байгалийн нөөцийн төлбөрийн орлогын төлөвлөлтийн саналыг авч нэгтгэн аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст ирүүлж, төсвийн төсөл боловсруулж байна. Сангийн яаманд хүргүүлсэн төсвийн төслийг 2021-2023 оноор харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №-11

/сая төгрөг/

№	Орлогын нэр төрөл	2021 он	2022 он	2023 он	2023 оны орлогын төсвийн төсөлд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг өмнөх оноос 990.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн нь
1	Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого	21.7	20.2	36.7	
2	Ус, рашаан ашигласны төлбөрийн орлого	36.9	45.4	56.3	
3	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	905.1	1,170.4	2,160.9	
4	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	120.8	107.9	168.9	
	Нийт дүн	1,084.6	1,343.9	2,422.9	

өмнөх онд орлого давж биелсэн болон 2022 оноос шинээр хэрэгжиж эхэлсэн Байгаль орчны мэдээллийн санд сум бүр өөрийн төлөвлөлтийн мэдээллээ оруулж, тус мэдээллээс аймгийн БОАЖГ орлогын төлөвлөлтийг нэгтгэж ирүүлэхдээ хяналтыг хангалтгүй хийж 207.7 сая төгрөгөөр илүү нэгтгэж ирүүлсэнтэй холбоотой байна.

Аймгийн БОАЖГ-ын ойн нөөцийн орлогын үнэт цаасны тооцоогоор 2021 онд 2,732.9 сая төгрөг, 2022 онд 5,003.0 сая төгрөгийн зөвшөөрлийг олгосон байна.

Хүснэгт №-12

Он	БОАЖГ /үнэт цаас	СТСХ-ийн гүйцэтгэл	Зөрүү	Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн гүйцэтгэлээр 2021 онд 2,828.9 сая төгрөг, 2022 онд 4,982.9 сая төгрөг нийт 7,811.8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.
2021	2,732.9	2,828.9	95.9	
2022	5,003.0	4,982.9	-20.1	
Дүн	7,735.9	7,811.8	75.8	

Ойн нөөц ашиглах зөвшөөрлийн орлогын дүн аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн гүйцэтгэлээс 2021 онд 95.9 сая төгрөгөөр илүү, 2022 онд 20.1 сая төгрөгөөр дутуу нийт 75.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Б.1.3 Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгох асуудалд байгаль орчны салбарын ажилчдын хамтын ажиллагаа, хяналт хангалтгүй байна.

Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийн эрхийн бичгийг сумдын байгаль хамгаалагч нараас олгож төлбөр төлөлтөд сумын санхүүгийн алба, татварын байцаагчтай хамтран хяналтыг хэрэгжүүлж байна.

Аудитаар байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг олгосон байдалд түүвэр хяналт хэрэгжүүлэхэд Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа зарим аж ахуйн нэгжид ус ашиглах зөвшөөрөл олгож, дүгнэлт гараагүй байна. **Тухайлбал:** Мөрөн суманд үйл ажиллагаа явуулдаг Хөвсгөл центр ХХК нь 2018 онд худаг гаргуулж, худгийн паспортоо авсан хэдий ч 2023 оны 5 дугаар сард ус ашиглах дүгнэлт гаргуулахаар хүсэлтээ БОАЖГ-т ирүүлсэн байна.

БОАЖГ-аас 2021 онд Мөрөн сумын байгаль орчны улсын байцаагчтай хамтран хэрэгжүүлсэн хяналтаар тус байгууллагад ажиллах ус ашиглах болон хаягдал усны дүгнэлтийг гаргуулах шаардлагатай талаар уулзсанаас өөрөөр дорвитой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аудитын хугацаанд тус зөрчлийг арилгаж 2022 он, 2023 оны дүгнэлт гаргуулах хугацаа хүртэлх цэвэр усны төлбөр 1.5 сая төгрөг, хаягдал усны төлбөр 1.0 сая төгрөг нийт 2.5 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр Хөвсгөл центр ХХК-д нэхэмжлэх үүсгүүлж зөрчлийг залрууллаа.

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргаанаас хаягдал усны төлбөр төлөх байгууллагуудын жагсаалтыг гаргуулж, хаягдал усыг зохих журмын дагуу байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Б1.4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж чадахгүйгээс орлого нэр төрлөөрөө тасардаг зөрчил жил бүр давтагдсаар байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2021 онд 1,921.3 сая төгрөгөөр, 2022 онд 2,005.4 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлийг хангуулсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлийн 2021-2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэл дараах байдалтай байна.

Хүснэгт №-13

/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	2021 он			2022 он		
		Төлөв	Гүйц	Зөрүү	Төлөв	Гүйц	Зөрүү
1	Байгалийн ургамал	20.6	30.2	(9.6)	25.2	25.2	-
2	Ус, рашаан	58.1	43.3	16.0	56.8	62.3	(5.5)
3	Ойн нөөц	1,689.0	2,828.9	(1,139.9)	1,741.9	4,982.9	(3,241.0)
4	Ан амьтны нөөц	153.6	415.2	(261.6)	181.5	424.9	(243.4)
	Нийт дүн	1,921.3	3,317.6	(1,395.1)	2,005.4	5,495.3	(3,489.9)

Ус рашаан ашигласны төлбөрийн орлого 2021 онд 16.0 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Номин тав трейд ХХК-ний усан онгоц Ковид-19 цар тахлын улмаас үйлчилгээнд яваагүйгээс шалтгаалсан байна.

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 2021-2022 онд 40-65 хувиар давж биелсэн нь ойн сан бүхий сумдад хуш модны самар элбэг ургаж иргэд ашиг олох зорилгоор их хэмжээгээр бэлтгэсэнтэй холбоотой байна. Тухайн жилийн самрын ургацын урьдчилан тооцох боломжгүй учраас ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан өндөр дүнгээр төлөвлөх боломжгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлийг сум бүрээр хянаж үзэхэд дараах орлогуудыг тасалсан байна. **Үүнд:**

1. Ойн нөөц ашигласны төлбөр:

2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого:

Хүснэгт №-14

/сая төгрөг/

Сумын нэр	2022 он		
	төлөв	гүйц	зөрүү
Арбулаг	24.3	17.9	6.4
Бүрэнтогтох	45.2	43.9	1.3
Их-уул	63.2	56.4	6.8
Рашаант	60.7	51.2	9.5
Улаан-Уул	77.9	72.5	5.4
Ханх	51.6	45.5	6.1
Цэцэрлэг	40.4	37.1	3.3

Сумын нэр	2021 он			2022 он		
	төлөв	гүйц	зөрүү	төлөв	гүйц	зөрүү
Баянзүрх	20.0	0.3	19.7	-	-	-
Галт	0.5	0.3	0.2	0.7	0.3	0.4
Рашаант	1.0	1.0	-	0.4	0.1	0.3
Төмөрбулаг	2.6	0.2	2.4	0.1	0.1	-
Улаан-Уул	0.9	0.6	0.3	1.1	0.6	0.5
Ханх	1.5	0.3	1.2	2.8	2.3	0.5
Чандмань-Өндөр	1.5	1.2	0.3	2.1	1.2	0.9

Байгалийн нөөц ашигласны төлбөрийг нэр төрөл тус бүрээр нь жигд хангаж ажиллахгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцээгүй, төсвийн өмнө хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажиллахгүй байгааг харуулж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 79 дүгээр тогтоолоор ургамал ашигласны төлбөрийн хувь хэмжээ, 80 дугаар тогтоолоор рашаан ашигласны төлбөрийн хувь хэмжээг хуульд заасан хязгаарт багтаан тогтоосон байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т заасан хугацаанд орлогын тайлан мэдээг гаргаж холбогдох дээд байгууллагуудад тайлагнаж байна. Гэвч аймгийн Татварын хэлтсээс тайлангийн ногдуулалт, төлөлтийн бодит байдалд хяналт хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Хүснэгт №-15

/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	Төлөлт 2021			Төлөлт 2022		
		Төрийн сан	Татвар	Зөрүү	Төрийн сан	Татвар	Зөрүү
1	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	2,828.9	2,828.2	0.7	4,982.9	4,996.0	(13.1)
2	Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого	30.2	28.9	1.2	25.2	30.0	(4.8)
3	Ус, рашаан ашигласны төлбөрийн орлого	43.3	63.2	(19.9)	62.3	92.0	(29.7)
4	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	415.2	412.4	2.8	424.9	298.5	126.3
	Нийт	3,317.6	3,332.8	(15.2)	5,495.3	5,416.6	78.7

Төрийн сангийн хуулгыг татварын системийн төлөлттэй тулган хянахад 2021 онд 15.2 сая төгрөг, 2022 онд 78.7 сая төгрөгийн зөрүүтэй байна. Тус зөрүүг сум бүрээр тулгалт хийхэд замд яваа мөнгө болон орлогыг татварыг системд дутуу бүртгэсэнтэй холбоотой байна.

Татварын ногдуулалтыг хянаж үзвэл:

Хүснэгт №-16

№	Орлогын төрөл	2021 он			2022 он		
		Татвар	Эрхийн бичиг	Зөрүү	Татвар	Эрхийн бичиг	Зөрүү
1	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	43.8	415.2	-371.4	354.5	424.9	-70.4
2	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	29.7	30.2	-0.5	36.1	25.2	10.9

Дээрх хүснэгтээс харахад ан амьтны нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг 2021 онд 371.4 сая төгрөг, 2022 онд 70.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Бүрэнтогтох, Рэнчинлхүмбэ, Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдаас бусад сумд татварын ногдуулалтыг хийж тайлагнаагүй байна. Энэ нь татварын бүртгэлд байгалийн нөөцийн төрлийн орлогын ногдуулалтыг үнэн зөв хийж тайлагнахгүй байгааг харуулж байна.

Татварын өр төлбөрийн үлдэгдлийг авч үзвэл:

Хүснэгт №-17

/сая төгрөг/

№	Байгалийн нөөцийн төрөл	Сумын нэр	Өр төлбөрийн үлдэгдэл	Байгалийн нөөц ашигласны төлбөртэй холбоотой 123.9 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг сумын татварын байцаагч, санхүүгийн албатай тулгалт хийж үзэхэд төлөлтүүд нь төрийн сангийн дансанд төлөлт хийгдсэн боловч Татварын системд
1	Ан амьтан	Цагаан-Үүр	34.4	Байгалийн нөөц ашигласны төлбөртэй холбоотой 123.9 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг сумын татварын байцаагч, санхүүгийн албатай тулгалт хийж үзэхэд төлөлтүүд нь төрийн сангийн дансанд төлөлт хийгдсэн боловч Татварын системд
2	Ан амьтан	Цагааннуур	22.0	
3	Ан амьтан	Эрдэнэбулган	0.3	
4	Ургамал	Баянзүрх	1.8	
5	Ургамал	Их-Уул	0.2	
6	Ус рашаан	Цагаан-Үүр	1.6	
7	Ус үйлдвэрлэл	Сумдын ЗДТГ	67.2	
	Нийт		127.9	

бүртгэгдээгүй, сумдын ЗДТГ дээр үүссэн үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Дээрх зөрчлүүдээс харахад Татварын хэлтэс нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг үнэн зөв хийж тайлагнасан эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй, төлөлтийг бүрэн

бүртгэдэггүй, өр төлбөрийг анхан шатны баримттай тулгалт хийж баталгаажуулаагүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 “Татварын алба нь энэ хуулийн 33.1.2-т заасан бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн хөтлөх бөгөөд татвар төлөгч бүрийн төлбөл зохих татварын ногдол, хөнгөлөлт, чөлөөлөлт, алданги, торгууль, тэдгээрийн төлөлт, өрийг анхан шатны баримтад үндэслэн татварын бүртгэлд бүрэн тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна. 2019 онд Байгалийн нөөцийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, байгаль хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд 1 **албан шаардлага** хүргүүлж байна.

Б2. БОХНСАХ-ний зардлаас төсвийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсантай холбоотой нийт 256.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд 2021-2023 онд 5,046.7 сая төгрөгийн төсвийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №-18

/ Сая төгрөг /

Он	Өмнөх оны давсан орлого	Орлого төлөвлөгөө	Нийт орлого	БОХНСАХ-д зарцуулахаар баталсан төсөв	Хуулиар зарцуулах дүн хувь	Зөрүү
2021	1,049.2	2,254.9	3,304.1	1,300.7	2,431.2	-1,130.5
2022	1,030.7	2,447.7	3,478.4	1,470.0	2,438.6	-968.6
2023	1,946.7	2,708.7	4,655.4	2,276.0	3,375.8	-1,099.8
Дүн	4,026.6	7,411.3	11,437.9	5,046.7	8,245.6	-3,198.9

Хөвсгөл аймгийн хэмжээнд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1²-т заасан хувь хэмжээгээр төлөвлөөгүйгээс 2021 онд 1,130.5 сая төгрөг, 2022 онд 968.6 сая төгрөг, 2023 онд 1,099.8 сая төгрөг нийт 3,198.9 сая төгрөгийг дутуу тооцож, хуваарилагдаагүй орлогыг хөрөнгө оруулалт болон төсвийн урсгал зардалд зарцуулахаар төлөвлөсөн тул **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ. **Тухайлбал:**

- Чандмань-Өндөр сум 2021 онд 195.0 сая төгрөгөөр, 2022 онд 420.4 сая төгрөгөөр, 2023 онд 60.1 сая төгрөгөөр
- Цагаан-Үүр сум 2023 онд 34.2 сая төгрөгөөр
- Эрдэнэбулган сум 2021 онд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 569.5 сая төгрөгөөр, 2022 онд 175.3 сая төгрөгөөр, 2023 онд 1,330.9 сая төгрөгөөр
- Тариалан сум 2021 онд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 395.8 сая төгрөгөөр, 2022 онд 135.6 сая төгрөгөөр, 2023 онд 314.5 сая төгрөгөөр дутуу тооцож төлөвлөсөн.

Аймгийн БОАЖГ-ын байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөөнд аймгийн ИТХ-аас 220.0 сая төгрөгөөр өдөр шөнийн тоолуур худалдан авч айл өрхүүдэд олгохоор шийдвэр гаргаж баталсан байна. Энэ нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.7 "Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2022 оныг хүртэл Байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгийн 60 хувийг аймагт, 40 хувийг сумдад хуваарилан зарцуулсан байна. Хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

²18.1.Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

Хүснэгт №-19

/сая төгрөг/

Он	Нийт төсөв	Суманд 40%	Аймагт 60%
2021	1,300.7	520.3	780.4
2022	1,470.0	588.0	882.0
2023	2,276.0	2,276.0	

Байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийг аймаг, сумдад дээрх байдлаар хуваарилж байгаа нь хууль, журамд заасан тухайн ашигласан байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд бүрэн

зарцуулах боломжийг бүрдүүлэхгүй байх үндсэн шалтгаан болсон байна. **Тухайлбал** 2021-2022 онд Тариалан сум 625.3 сая төгрөг төвлөрүүлсэн байхад 50.5 сая төгрөгийг БОХНСАХ-д баталсан, Цагаан-Үүр сум 1,196.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байхад БОХНСАХ-д 44.9 сая төгрөгийг, Эрдэнэбулган сум 2,047.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байхад БОХНСАХ зардалд 75.8 сая төгрөгийг баталсан байна.

Нөгөө талаар тухайн суманд байгалийн нөөцийг нөхөн сэргээх онцгой шаардлага байхгүй бол шаардлагатай бүс нутагт шилжүүлсэн зарцуулах хуулийн зохицуулалт байхгүйгээс тус хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулах нөхцөл байдлыг бий болгож байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2023 оноос эхлэн тухайн орлогыг бүрдүүлсэн бүс нутагт зарцуулахаар төлөвлөн хуваарилсан байна.

БОХНСАХ-ний зардлыг харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №-20

/сая төгрөг/

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2021	1,300.7	945.8	354.9
2022	1,470.0	1,306.7	163.3
2023	2,276.0	-	-

БОХНСАХ зардалд 2021 онд 945.9 сая төгрөг, 2022 онд 1,306.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

БОХНСАХ-ний төсвийн зарцуулалтын талаар:

БОХНСАХ-ний зардлаас төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсантай холбоотой нийт 256.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

Хүснэгт №-21

Сумын нэр	Зөрчлийн утга
Эрдэнэбулган	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Жигүүр ой ХХК-д 99 суулгачын үнэ гэж 2.6 сая төгрөгийг шилжүүлэн боловч суулгац худалдан авсан нь нотлогдохгүй байна. Санхүүгийн тайланд материалыг хүлээн аваагүй байж орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.
Чандмань-Өндөр	Байгал хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд баталсан төсвийг хог цэвэрлэгээ, хогны байцаагч жолоочийн урамшуулал, мөн байгаль орчныг хамгаалах самбар байршуулах /тус самбарууд нь малын эрүүл ахуй, архидалт зэрэгтэй холбоотой. БОХНСАХ-ийн зардлаас модны бут сөөг худалдан авч иргэдэд тараасан хэдий ч тус мод нь зах зээлийн үнэлгээнээс 0.5 сая төгрөгөөр өндрөөр худалдан авсан
Нарс шинэсэн төгөл СДОА	2021 онд Чандмань-өндөр сумын БОХНСАХ-ий зардлаас 1.0 сая төгрөгийн дэмжлэг авч 2 принтер худалдан авахаар гэрээ хийсэн боловч бодит нөхцөлд 1 принтер худалдан авсан бөгөөд 0.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан
БОАЖГ	БОАЖГ нь 2021 онд БОХНСАХ зардлаас 29.7 сая төгрөгийн зардал гаргаж ISO стандартыг нэвтрүүлсэн.
	БОХНСАХ зардлаас 2021 онд нийт 5.4 төгрөгийн албан томилолтын зардал гаргасан
	БОХНСАХ зардлаас 2021 онд 6.5 сая төгрөг, 2022 онд 12.8 сая төгрөгийг сургалтын хоол хүнсний зардалд зарцуулсан
	БОХНСАХ зардлаас 2021 онд 2.0 сая төгрөг, 2022 онд 2.0 сая төгрөг төгрөгийн интернэтийн зардлыг гаргасан байна.
	2021 онд БОХНСАХ зардлаас 10.0 сая төгрөгийг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авсан.
	Эрчим илч түлш ХХК-д олгосон 24.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон хэдий ч компанийн үйл ажиллагаа явагдаагүй захирал, нягтлан бодогчийн цалингийн зардалд зарцуулж үр ашиггүй зардал гаргасан.
	Байгууллагын төсвөөс 2022 онд нийт 5.0 төгрөгийг хоол хүнс, бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан бөгөөд анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

	Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд 30.0 сая төгрөгийн 156 ширхэг өдөр шөнийн тоолуур худалдан авч айл өрхүүдэд олгосон
Галт	2021 онд БОХНСАХ-ний зардлаар ногоон зурвас байгуулах ажилд 2.8 сая төгрөгийн өртөгтэй суулгац тарьсан боловч үр дүн гараагүй байна.
Жаргалант	2021 онд БОХНСАХ-ний зардлын төсвөөс зориулалт бусаар нийт 110.5 сая төгрөгийг авто машин худалдан авах, гүүр барих, авто зогсоол байгуулах, авто зам засах зэрэг хөрөнгө оруулалтуудад зарцуулсан байна. Ойн зурвас байгуулах 12.0 сая төгрөгийн төсөвтэй ажил хэрэгжүүлсэн боловч тарьсан суулгац ургаагүй, үр дүнд хүрээгүй байна.

Дээрх зөрчлүүдэд 32.6 сая төгрөгийн 5 төлбөрийн актыг тогтоож, 223.7 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

БОХНСАХ-ний зардлыг төлөвлөхдөө хуульд заасан хувь хэмжээгээр бүрэн тооцож төлөвлөөгүй, зориулалт бус зүйлд зарцуулж байгаа нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний ажлын үр дүнг бууруулж байна.


В. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийгээгүй цаашид авах арга хэмжээг тодорхойлж ажиллаагүй байна.

Аймгийн БОАЖГ нь байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төсөв, зарцуулалт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, байгаль орчинд учруулсан нөхөн төлөлтийн мэдээлэл, байгаль орчны холбогдолтой гэмт хэргийн зөрчлийн мэдээлэл, байгалийн нөөц ашигласан иргэн аж ахуй нэгж байгууллагууд болон холбогдох байгууллагуудын үйл үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээллийг нэгтгэн боловсруулж ил тод мэдээлэн тайлагнаж ажиллах чиг үүрэгтэй байна.

Байгаль орчны талаарх мэдээллийг 2021 оноос eic.mn сайтад байгаль хамгаалагчид болон холбогдох ажилтнууд мэдээллийг байршуулж ажилласан байна. Уг сайтад байгалийн нөөцийг тогтоосон мэдээлэл, тайлант онд олгох зөвшөөрлийн тоо хэмжээг мэдээлсэн боловч хэдэн иргэн, аж ахуй нэгжид хэр хэмжээний зөвшөөрөл олгосон, төлбөрийн орлогын бүрдүүлэлтийн гүйцэтгэлийн мэдээллийг тусгах боломжгүй байна.

Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын бүтэц зохион байгуулалтыг графикаар харуулбал дараах байдалтай байна.

Графикаар №-1



Байгаль орчин аялал жуулчлалын газар нь сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулж ажиллах эрх зүйн орчин байхгүй, нэгдсэн байдлаар байгаль хамгаалах нөхөн сэргээх арга

хэмжээний чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг сумдад хүргэхэд төсөв, санхүү болон орон нутгийн онцлогоос хамааран өөрчилж баталдаг нь нэгдсэн бодлого арга зүйгээр хангаж ажиллахад хүндрэл учруулж байна.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх чиг үүргийг БОАЖГ нь хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч Хөвсгөл нуур - Эгийн голын сав газрын захиргаа, Дэлгэр мөрөн Шишхэд голын сав газрын захиргаа нь тусдаа усны чиглэлээр бие даасан үйл ажиллагааг явуулж байна.

БОАЖГ нь нэгдсэн мэдээ тайлан гаргах мэдээллийн сан бүрдүүлэхэд дараах хүндрэлүүд үүсэж байна. Тухайлбал:

- Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргаа, Дэлгэр мөрөн Шишхэд голын сав газрын захиргаа нь БОАЖС-тай гэрээ байгуулан усны газарт мэдээ, тайлангаа нэгтгүүлдэг
- Сумдын Засаг дарга нар аймгийн Засаг даргад гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлаа дүгнүүлдэг
- Сум дундын Ойн ангиуд аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан гүйцэтгэл үр дүнг тооцуулдаг.
- Eic.mn цахим хуудсыг 2022 оноос эхлэн ашиглаж байгаа хэдий ч үйл ажиллагаа нь бүрэн жигдрээгүй.

Дээрх хүндрэлээс харахад Хөвсгөл аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар нь аймгийн хэмжээний эрхлэх хүрээний нэгдсэн мэдээллийн санг бүрэн, үнэн зөв бүрдүүлж чадахгүй байна.

В.2. Хөвсгөл аймгийн БОАЖГ-аас дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, санхүүгийн хяналт, аудитын алба болон төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчил давтагдаж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд аймаг сумдын ИТХ, бүх шатны Засаг дарга нар хяналт тавьж ажиллахаар хууль тогтоомжид заасан байна.

Аймгийн хэмжээнд байгалийн нөөц ашиглаж байгаа аж ахуй нэгж байгууллагуудад байгаль орчны аудитыг хийлгэх хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулаагүй нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 “Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн БОАЖГ нь аймгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаа болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавьж хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна.

БОАЖГ-ын дотоод хяналтын нэгж нь байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтийн байдал, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийн талаар хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1. “хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт болон тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалт” хийнэ гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа тул дотоод хяналтыг сайжруулж ажиллах **албан шаардлага** өгөхөөр шийдвэрлэлээ.

Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт хуваарилалтын чиглэлээр 2021 онд Жаргалант, Хатгал тосгон, Төмөрбулаг, Баянзүрх Улаан-Уул, Цагааннуур, Цагаан-Уул, Эрдэнэбулган, Галт зэрэг сумдад 2022 онд Түнэл Тосонцэнгэл, Ханх, Арбулаг, Шинэ-Идэр,

Рашаант сумдад хяналт хийж БОХНСАХ-ний зардлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хэмжээгээр төсвийг бодитой тооцож төлөвлөн зарцуулах, анхан шатны баримтын бүрдүүлэлт, байгаль хамгаалагчдыг эргүүл хяналт хийж гүйцэтгэсэн чиглэлийн талаар үр дүнг тооцож ажиллах зэрэг зөвлөмжүүдийг өгсөн байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас 2019 онд гүйцэтгэсэн “Байгалийн нөөцийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Тухайн онд ногдуулсан төлбөрийн орлогыг оруулаагүй иргэн, аж ахуйн нэгжээс авлага үүсгэж тайланд тусгаагүй, илүү төлөлтийг тооцож өглөг үүсгээгүй байна.
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т заасан хувь хэмжээгээр төлөвлөөгүй байна.
- байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зориулалт бусаар зарцуулсан арга хэмжээ /559.1 сая төгрөг /
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн төсөл арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлын үр дүнг тооцон ажиллахгүй байна
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт аудитын алба болон аймгийн БОАЖГ-аас хяналт шалгалтыг удаа дараа хийж байгаа боловч бодит үр дүн гараагүй, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал давтагдсан.

Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн дээрх зөрчилд нийт 12 хугацаатай зөвлөмжийг өгсөн боловч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж зөрчлийг арилгаж ажиллаагүй бөгөөд зөрчил давтагдаж байна.

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос 2022 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлуудад хяналтыг хэрэгжүүлэн байна: Үүнд

- Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн", "Мод тарьж Ногоон суварга босгоё аян"-ны хүрээнд төв суурин газрын орчинд ойн зурвас байгуулах ажил
- Сум дундын ойн ангиудыг өөрийн байртай болгох, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх
- “Уранмандал уул”-ын араас засмал зам хүртэлх ойн зурвасын хашаа барих, үр бэлтгэх, арчлах мод тарих арга хэмжээг хэрэгжүүлэх
- Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар авто зогсоол бүхий отоглох цэг
- Ойн сан бүхий газарт хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх "Хоггүй цэвэрхэн Монгол аян"-ны хэрэгжилттэй танилцах
- Ойн мэргэжлийн байгууллагуудын талбай тусгаарлалт, тусгаарласан талбайг хүлээлгэж өгсөн байдалд хяналт хийж, үнэлгээ өгөх
- Ойн мэргэжлийн байгууллагуудын мэргэшлийн үйл ажиллагаанд дүгнэлт хийх
- Ойн мэргэжлийн байгууллагуудын ойжуулалт нөхөн сэргээлтийн ажлын үр дүнтэй танилцах чиглэлээр хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хөвсгөл аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос анхаарах асуудлуудад тухай бүр зөвлөмж өгч ажилласан байна.

Аудитаар нийт 4,327.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж 4,294.7 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага өгч, 32.6 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн актыг тогтоож 11 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгсөн.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь зарим хууль тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй, орон нутагт хэрэгжүүлэх боломж бүрдээгүй, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээхтэй холбоотой менежментийн төлөвлөгөөг аймгийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлсэн боловч зарим менежментийн төлөвлөгөөний хэрэгжих хугацаа дууссан, төлөвлөсөн зарим үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
2. БОАЖГ, Ойн ангиуд, сав газрын захиргаанууд зөвхөн аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө болон гэрээ байгуулан ажиллаж байгаагаас аймгийн БОАЖГ нь нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль орчны чиглэлээр нэгдсэн бодлого барьж, хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна.
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хууль, журмын дагуу төлөвлөж, ногдуулалт хийж, гүйцэтгэлийг хангуулж, үнэн зөв тайлагнаагүй, мэдээллийн санг бүрэн бүрдүүлээгүй нь аймаг, сумдын байгаль хамгаалагч, татварын байцаагч нарын ажлын уялдаа холбоо, түүнд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.
4. БОХНСАХ-ний зардлыг төлөвлөхдөө хуульд заасан хувь хэмжээгээр бүрэн тооцож төлөвлөөгүй, зориулалт бус зүйлд зарцуулсан, шат шатны иргэдийн хурлаас хууль журамд нийцээгүй төсөл арга хэмжээг баталж байгаа нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний ажлын үр дүнг бууруулж байна.
5. Аймгийн БОАЖГ-аас дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, санхүүгийн хяналт, аудитын алба болон төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчил давтагдаж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт:

1. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хууль, журамд заасан зориулалт, хувь хэмжээнд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах.

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, нэр төрөл тус бүрээр нь гүйцэтгэлийг жигд ханган биелүүлэх, үнэн зөв тайлагнаж ажиллах
3. Байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасан хувь хэмжээгээр тооцох
4. БОХНСАХЗ-ыг Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу төлөвлөн, зориулалтын дагуу зарцуулах, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн БОАЖГ-ын дарга П.Мөнхжаргалд:

1. БОАЖГ-аас хэрэгжүүлж буй хяналтын үр дүнг тооцож хэрэгжилтийг үнэлж ажиллах
2. Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг хэрэгжүүлж БОХНСАХ-нд зарцуулах зардлыг үнэн зөв төлөвлөж зарцуулах.
3. Ахуйн зориулалтаар агнах барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоохдоо БОАЖЯ-ы сайдын тушаалаар баталсан дээд хязгаарыг баримталж ажиллах.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базарт:

4. Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дах хэсгийг хэрэгжүүлэн, хяналтыг сайжруулж ажиллах.

Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргааны дарга Б.Энхгэрэлд:

5. Дэлгэрмөрөн голын сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэн ажиллах.

Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргааны дарга Д.Эрдэнэболд-д:

6. Эгийн голын сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэн ажиллах
7. Хаягдал ус ашиглагч байгууллагуудын судалгааг гаргаж, ус бохирдуулсны төлбөрийн гэрээг байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах.

Зөрчлийн жагсаалт

№	Аудитаар илэрсэн		Өгсөн албан шаардлага		Тавьсан акт		Зөвлөмж	
	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төг/	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Ойн хөнөөлт шавжийн тархалт, голомтын талбайг хянаж, тэмцлийг оновчтой явуулах зорилгоор судалгааны талбайг нэмэгдүүлэх ажлыг хийгээгүй байна. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх химийн аргын хэрэглээг бууруулж, биологийн аргыг түлхүү хэрэглэж ойн хөнөөлт шавжийн тархалт, голомттой талбайд тэмцэх ажлыг 2022 онд 50 гад-д хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 3.6 га талбайд буюу 0.7 хувьтай хэрэгжүүлсэн							
2	Бүх нийтээр мод тарих өдрийн бут ургуулах ажлын хүрээнд 2021 онд төлөвлөгөөнөөс 19,480 ширхэг, 2.4 га талбайд мод бутыг дутуу тарьсан.							
3	Хамгааллын Ойн зурвас байгуулах байгуулах ажлын хүрээнд 2021 онд 8.3 га талбайд ойн зурвас байгуулахаар төлөвлөж 2.1 га талбайд ойн зурвас байгуулж 6.2 га талбайн ажил хийгдээгүй		1				1	
4	Ногоон байгууламж байгуулах ажлын хүрээнд 2021 онд төлөвлөсөн 2 га талбайд ногоон зурвас байгуулах ажлыг гүйцэтгээгүй байна.							
5	Ойжуулалт нөхөн сэргээх ажлыг 2021 онд 1,374 га талбайд хийхээр төлөвлөж гүйцэтгэлээр 233.6 га буюу 17 хувь, 2022 онд 1,443 га талбайд төлөвлөж гүйцэтгэлээр 161 га буюу 11.1 хувьтай ойн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд гүйцэтгэл хангалтгүй байна.							
6	Ахуйн зориулалтаар агнах барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоохдоо БОАЖЯ-ы сайдын тушаалаар баталсан дээд хязгаарыг баримтлаагүй байна.						1	
7	Мөрөн сумын айл өрхүүдийг цахилгаанаар халаалтаа шийдвэрлэх боломж бүрдүүлэх ажлын хүрээнд 156 ширхэг өдөр шөнийн тоолуур авч айл өрхүүдэд олгосон	30.0		30.0				
8	БОАЖГ нь 2021 онд БОХНСАХ зардлаас 29.7 сая төгрөгийн зардал гаргаж ISO стандартыг нэвтрүүлсэн байна.	29.7		29.7				
10	БОХНСАХ зардлаас 2021 онд нийт 5.4 сая төгрөгийн албан томилолтын зардал гаргасан	5.4	1	5.4			1	
9	2021 онд БОХНСАХ зардлаас 6.5 сая төгрөг, 2022 онд 12.8 сая төгрөгийн зардлыг сургалтын хоол хүнсний зардалд зарцуулсан байна.	19.3		19.3				
10	БОХНСАХ зардлаас 2021 онд 2.0 сая төгрөг, 2022 онд 2.0 сая төгрөгийн интернэтийн зардлыг гаргасан байна.	4.0		4.0				
11	Эрчим илч түлш ХХК-д олгосон 24.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон хэдий ч компанийн үйл ажиллагаа	24.0			1	24.0		

	явагдаагүй захирал, нягтлан бодогчийн цалингийн зардал зарцуулж үр ашиггүй зардал гаргасан.						
12	2021 онд БОХНСАХ зардлаас 10.0 сая төгрөгийг техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авсан.	10.0		10.0			
13	БОАЖГ нь байгууллагын төсвөөс 2022 онд нийт 5.0 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан бөгөөд анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.	5.0			1	5.0	
14	2023 оны төсвийн төлөвлөлтөд ан амьтны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ургамал хамгаалах зэрэг яг ямар үйл ажиллагаанд зарцуулах нь тодорхойгүй зардлуудад төлөвлөсөн зэрэг асуудлууд илэрсэн.					1	
15	Мөрөн сумын айл өрхүүдийг цахилгаанаар халаалтаа шийдвэрлэх боломж бүрдүүлэх ажлын хүрээнд аймгийн ИТХ-аас 220.0 сая төгрөгөөр өдөр шөнийн тоолуур худалдан авч айл өрхүүдэд олгохоор шийдвэр гаргаж төсөв баталсан.	220.0	1	220.0			
16	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож төлөвлөөгүй	3,198.9	1	3,198.9		1	
17	БОАЖГ нь аймгийн хэмжээний байгалийн нөөц ашиглалт, нөхөн сэргээлт, орлого бүрдүүлэлт зарцуулалтын дэлгэрэнгүй бүртгэл, нэгдсэн мэдээ тайланг гаргаж хэрэгжилтийг тооцоогүй					1	
18	Аймгийн хэмжээнд байгалийн нөөц ашиглаж байгаа аж ахуй нэгж байгууллагуудад байгаль орчны аудитыг хийлгэх хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулаагүй		1			1	
19	БОАЖГ-ын Байгууллагын дотоод хяналт нь байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтийн байдал, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийн талаар хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй.					1	
20	Дэлгэрмөрөн голын сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулаагүй					1	
21	Эгийн голын сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэн ажиллах					1	
22	Хаягдал ус ашиглагч байгууллагуудын судалгааг гаргаж, ус бохирдуулсны төлбөрийн гэрээг байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажилла					1	
23	Төрийн сангийн хуулгыг татварын системийн төлөлттэй харьцуулахад 2021 онд 15.2 сая төгрөг, 2022 онд 78.7 сая төгрөгийн зөрүүтэй байна. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг татварын тайланд 371.4 сая төгрөгөөр, 2022 онд 70.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Ургамлын нөөц ашигласны төлбөрийг 2022 онд 10.9 сая төгрөгөөр илүү тооцож тайлагнасан. Татварын ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл	652.1	1	652.1			

	дэх 127.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг сумын татварын байцаагч, санхүүгийн албатай тулгалт хийж үзэхэд эдгээр төлөлтүүд нь Төрийн сангийн дансанд төлөлт хийгдсэн боловч Татварын системд бүртгэгдээгүй байна.						
24	Эрдэнэбулган сумын ЗДТГ нь байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Жигүүр ой ХХК-д 99 суулгацын үнэ гэж 2.6 сая төгрөгийг шилжүүлэн боловч суулгац худалдан авсан нь нотлогдохгүй байна. Санхүүгийн тайланд материалыг хүлээн аваагүй байж орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан	2.6			1	2.6	
25	БОХНСАХ-ийн зардлаас модны бут сөөг худалдан авч иргэдэд тараасан хэдий ч тус мод нь зах зээлийн үнэлгээнээс 0.5 сая төгрөгөөр өндрөөр худалдан авсан	0.5			1	0.5	
26	2021 онд Чандмань-өндөр сумын БОХНСАХ-ий зардлаас 1.0 сая төгрөгийн дэмжлэг авч 2 принтер худалдан авахаар гэрээ хийсэн боловч бодит нөхцөлд 1 принтер худалдан авсан байна. Иймд зөрүү 0.5 сая төгрөг байна.	0.5			1	0.5	
27	Галт сумын БОХНСАХ-ний зардлаар 2021 онд ногоон зурвас байгуулах ажилд 2.8 сая төгрөгийн өртөгтэй суулгац тарьсан боловч үр дүн гараагүй	2.8	1	2.8			
28	Жаргалант сумын БОХНСАХ-ний зардлын төсвөөс 2021 онд зориулалт бусаар нийт 110.5 сая төгрөгийн өртөг бүхий 11 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд: Авто машин худалдан авах, гүүр барих, авто зогсоол байгуулах, авто зам засах зэрэг хөрөнгө оруулалтууд байна.	110.5	1	110.5			
29	Жаргалант суманд Ойн зурвас байгуулах 12.0 сая төгрөгийн төсөвтэй ажил хэрэгжүүлсэн боловч тарьсан суулгац ургаагүй, үр дүнд хүрээгүй.	12.0	1	12.0			
Нийт		4,327.3	9	4,294.7	5	32.6	11

Холбогдох байгууллагын санал тайлбар.

Байгууллагаас ирсэн санал тайлбар.	Хариу тайлбар
ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ ХӨВСГӨЛ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР 7 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120. Утас: 70384909 Цахим шуудан: bogior@khs.gov.mn Цахим хуудас: Khs.gov.mn/baigalorchin.gov.mn 2023.06.19 № 431 танай -ны № -т Тайлбар хүргүүлэх тухай Манай байгууллагын 2021, 2022 оны Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Үүнтэй холбоотой зөвлөмж, акт, албан шаардлагад дурдагдсан зүйлүүдэд дараах тайлбар хүргүүлж байна Үүнд: 1. БОАЖГазраас хэрэгжүүлж буй хяналтын үр дүнг тооцож хэрэгжилтийг үнэлж ажиллана. 2. Засгийн газрын 2002 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу төлөвлөн, зориулалтын дагуу зарцуулах, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлнэ. 3. Ахуйн зориулалтаар агнах барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоохдоо БОАЖЯСайдын тушаалаар баталсан дээд хязгаарыг баримтлан ажиллана. ДАРГЫН АЛБАН ХҮРЕЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.МӨНХЖАРГАЛ 671207-431 On Baiting/hauling/2023/06-19/01/001/0001	Санал ирүүлээгүй



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТАТВАРЫН ХЭЛТЭС**

Татаарын хэлтсийн байр, Уралдун 8 дугаар баг,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 6/120
Утас: 7038 2569, Цахим шуудан: tatvariinxeles@khs.gov.mn

2023.06.19 № 187
танай 2023.06.16 ны № 01/425 -Т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Хариу хүргүүлэх тухай

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Төсөлд буй ан амьтны нөөц ашигласны төлбөрийн 56.7 сая төгрөг, Байгалийн ургамал ашигласны төлбөрийн 2.0 сая төгрөг, Ус рашаан ашигласны төлбөрийн 1.6 сая төгрөг, үйлдвэрлэл үйлчилгээний усны төлбөрийн 67.2 сая төгрөгийн өрийг барагдуулах хэрэв төлөгдсөн бол орлогыг шивүүлж өрийг хааж ажиллах.

2022 оны тайлан ирүүлээгүй сумдаас төлбөр хураамжуудын тайланг нөхөж авах мөн төрийн сангийн мэдээтэй Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2021 онд 15.2 сая төгрөг, 2022 онд 78.7 сая төгрөгөөр зөрснийг засварлуулахаар сумдын байцаагчдад хугацаатай үүрэг өгч хэрэгжилтэд хяналт тавьж болно.

ДАРГА

Ч.ХУНШАГАЙ

**Санал ирүүлээгүй
байна.**

671202052



АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120,
Утас: 7038 3303, Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: www.khovsgol.gov.mn

Холбоо. 06.19 № 671001
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт нийцлийн аудит”-ын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангаар өгөгдсөн албан шаардлагыг биелүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллана.

Тус тайланд “Шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Эрчим илч түлш” ХХК-д олгосон 24.0 сая төгрөгийн санхүүжилтийг захирал, нягтлан бодогчийн цалингийн зардалд зарцуулсан байна” гэсэн зөрчлийн акт тавигдсан байна.

Энэ нь ойн нөөцийг хамгаалах, түлшинд мод орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл арга хэмжээ нь байсан бөгөөд үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор “Эрчим илч түлш” ХХК-д санхүүжилт олгосон.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр төлөвлөн аймгийн ИТХ-д оруулдаг боловч аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн саналаар нэр төрлийг өөрчлөх, шинээр төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр шийдвэрлэгдэж байгаа тул дээрх зөрчлийн актыг албан шаардлага болгох санал оруулж байна.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУДАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ОЮУНТУЯА



6712080133

*Хуулийн
үндэслэлтэй
санал ирүүлээгүй
тул саналыг
хүлээн авах
боломжгүй*



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 06 сарын 19 өдөр

№ 79/22260439/ХӨА-2023/01
МТА - НЯ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө хуульд заасан хувь хэмжээнээс 2021 онд 1,130,500,000.0 (нэг тэрбум нэг зуун гучин сая таван зуун мянга) төгрөгөөр, 2022 онд 968,600,000.0 (есөн зуун жаран найман сая зургаан зуун мянга) төгрөгөөр, 2023 онд 1,099,100,000.0 (нэг тэрбум ерэн есөн сая нэг зуун мянга) төгрөгөөр тус тус дутуу нийт 3,198,900,000.0 (гурван тэрбум нэг зуун ерэн найман сая есөн зуун мянга) төгрөгөөр дутуу тооцож төлөвлөсөн байна.

Дээрх зөрчил нь “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно” заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 “хууль тогтоомж ... зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасан хувь хэмжээний дагуу төлөвлөж ажиллах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР: Б.ДАВААНЯМ

1720090001 1070005

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 06 сарын 19 өдөр

№ 78/АБЭБОНЗЗ/ХАА-2023/01
ШТА - НА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн төлөлтийн төрийн сангийн хуулгыг татварын системийн төлөлттэй харьцуулахад 2021 онд 15,213,260.0 (арван таван сая хоёр зуун арван гурван мянга хоёр зуун жар) төгрөг, 2022 онд 78,656,175.0 (далан найман сая зургаан зуун тавин зургаан сая нэг зуун далан тав) төгрөгийн зөрүүтэй байна.
2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг татварын тайланд 2021 онд 371,400,696.0 (гурван зуун далан нэгэн сая дөрвөн зуун мянга зургаан зуун ерэн зургаа) төгрөгөөр, 2022 онд 70,375,540.0 (далан сая гурван зуун далан таван мянга таван зуун дөч) төгрөгөөр дутуу тайлагнасан байна.
3. Ургамлын нөөц ашигласны төлбөрийг 2022 онд 10,924,156.0 (арван сая есөн зуун хорин дөрвөн мянга нэг зуун тавин зургаа) төгрөгөөр илүү тооцож тайлагнасан.
4. Байгалийн нөөц ашигласны төлбөртэй холбоотой 123,943,893.0 (нэг зуун хорин гурван сая есөн зуун дөчин гурван мянга найман зуун ерэн гурав) төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг сумын татварын байцаагч, санхүүгийн албатай тулгалт хийж үзэхэд төлөлтүүд нь төрийн сангийн дансанд төлөлт хийгдсэн боловч Татварын системд бүртгэгдээгүй, сумдын ЗДТГ дээр үүссэн үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
5. “Байгалийн нөөцийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар ногдуулалт, тайлагналт, өр авлагатай холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дээрх зөрчил нь Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 “Татварын алба нь энэ хуулийн 33.1.2-т заасан бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн хөтлөх бөгөөд татвар төлөгч бүрийн төлбөл зохих татварын ногдол, хөнгөлөлт, чөлөөлөлт, алданги, торгууль, тэдгээрийн төлөлт, өрийг анхан шатны баримтад үндэслэн татварын бүртгэлд бүрэн тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй”, гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн төлөлт, ногдуулалтыг алдаатай бүртгэсэн, өр төлбөрийг тооцоо нийлж баримтжуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 01-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹ ирүүлэх;

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Татварын хэлтсийн дарга Ч.Хуншагай, бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга М.Бат-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЗБААТАР

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР: Б.ДАВААНЯМ





ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 06 сарын 19 өдөр

№ 20/АЭЭВД/39/ХӨА-2023/01
ШТА-НА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:
Жаргалант сумын ЗДТГ-ын Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төсвөөр 2021 онд хэрэгжүүлсэн 12,000,000.00 (арван хоёр сая) төгрөгийн төсөвтэй Үзэсгэлэнт Тайга ХХК-ийн гүйцэтгэсэн ногоон зурвас байгуулах ажил үр дүнгүй болж тарьсан суулгац ургаагүй байна.

Дээрх зөрчил нь “Ойн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.2 “сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 18.2.2 дахь “ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх” заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 “хууль тогтоомж ... зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, Үзэсгэлэнт тайга ХХК-аар дутуу ажлыг гүйцэтгүүлж, гэрээний биелэлтийг хангуулж ажиллах
